



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/400.

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 17.1.5, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны “Нийтлэг шаардлага батлах тухай” А/152 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”, “Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага” -ын хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагаанд нь үнэлгээ хийж, дүгнэлт гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Хүүхэд харах үйлчилгээ, Өдөр өнжүүлэх төвүүдийн хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын удирдамжийг боловсруулан хэрэгжүүлж, хэрэгжилтийн тайланг 2020 оны 09 дүгээр сарын 25-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг (Ж.Пүрэвсүрэн)-т үүрэг болгосугай.


ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100895

09 Аймгийн Засаг даргын 2020 оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Ж.Пүрэвсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх
Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
- Нарийн бичгийн дарга: Х.Гэрэлмаа -аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл,
хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ахлах
мэргэжилтэн, хүүхдийн эрхийн улсын байцаагч
- Гишүүд: Ц.Энхцэцэг – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн мэргэжилтэн
- Я.Жаргал- Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын
Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга
- Д.Нэргүй –Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын
газрын Боловсролын хяналтын улсын байцаагч
- Л.Алтаншагай –Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын
газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын
улсын байцаагч
- Б.Батсайхан –Аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын
газрын Гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагч
- Б.Баярмаа –Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл,
урлагийн газрын сургуулийн өмнөх боловсролын
байгууллага хариуцсан мэргэжилтэн
- Н.Нямсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл,
урлагийн газрын Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн